



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/124/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Энхтуяа Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuya_global@gmail.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНБУЛАГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА О.ГАНДИЙМАА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/77

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020406

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A large, stylized handwritten signature in black ink, written over a red rectangular stamp. The signature is slanted and extends across the width of the stamp.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,476,925.00</u>	<u>138,884,257.70</u>
33	АВЛАГА	00.00	110,239,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	110,239,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,476,925.00	28,645,257.70
351	Түүхий эд материал	6,552,905.00	8,045,300.00
35110	Тусгай зориулалттай материал	4,994,663.00	4,303,663.00
35130	Эм боох материал	1,558,242.00	3,741,637.00
354	Хангамжийн материал	17,924,020.00	20,599,957.70
35410	Бичиг хэргийн материал	1,432,320.00	1,805,320.00
35420	Аж ахуйн материал	12,036,300.00	9,513,536.97
35440	Түлш, шатах тослох материал	800,000.00	1,460,500.00
35460	Хүнсний материал	911,570.00	973,655.00
35470	Бусад хангамжийн материал	2,743,830.00	6,846,945.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,276,375,488.74</u>	<u>1,258,659,898.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,276,375,488.74	1,258,659,898.25
392	Биет хөрөнгө	1,274,944,188.70	1,257,283,598.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,260,025,835.00	1,260,025,835.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-89,034,662.28	-132,418,675.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,306,434.00	66,306,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,633,504.74	-29,684,577.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	142,291,779.00	195,873,228.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,752,863.69	-108,214,743.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,421,929.50	23,131,929.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,680,758.09	-17,735,833.59
393	Биет бус хөрөнгө	1,431,300.04	1,376,300.08
39301	Програм хангамж	670,000.00	670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-504,999.96	-559,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	1,266,300.00	1,266,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,300,852,413.74</u>	<u>1,397,544,155.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,366,300.00</u>	<u>59,655,752.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,366,300.00	59,655,752.00
413	Өглөг	2,366,300.00	59,655,752.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	41,164,566.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,366,300.00	9,989,586.00
4136	Бусад өглөг	00.00	8,501,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	8,501,600.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,298,486,113.74	1,337,888,403.95
51	Засгийн газрын хувь оролцоо	1,298,486,113.74	1,337,888,403.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	192,097,841.00	192,097,841.00
51101	Өмч: - төрийн	192,097,841.00	192,097,841.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,036,798,998.81	1,129,835,622.02
51210	Өмнөх үеийн үр дүн	1,047,318,038.63	1,100,952,371.63
51220	Тайлант үеийн үр дүн	-10,519,039.82	28,883,250.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,589,273.93	15,954,940.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,300,852,413.74	1,397,544,155.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	494,281,186.00	747,485,763.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,629,816.00	72,853,518.59
120	Нийтлэг татварын бус орлого	77,629,816.00	72,853,518.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,629,816.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,629,816.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		49,561,449.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		23,292,069.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,651,370.00	674,632,624.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,270,000.00	426,874,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,932,760.00	210,472,668.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,932,760.00	64,612,668.00
131107	нэмэлт		145,860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,090,400.00	20,084,927.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,090,400.00	20,084,927.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,358,210.00	17,200,250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,358,210.00	17,200,250.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486,804,006.82	708,083,473.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,804,006.82	708,083,473.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,804,006.82	706,689,814.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,356,368.00	349,019,915.00
210101	Үндсэн цалин	183,107,907.00	219,582,915.00
210102	Нэмэгдэл	72,420,261.00	96,453,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,082,000.00
210104	Урамшуулал	18,828,200.00	27,901,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,915,406.00	45,873,676.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	36,915,406.00	45,873,676.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,666,850.00	23,548,237.00
210301	Гэрэл, цахилгаан	2,589,550.00	2,156,927.00
210302	Түлш, халаалт	21,077,300.00	20,991,310.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,206,540.00	74,718,696.33
210401	Бичиг хэрэг	3,857,400.00	4,288,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,716,740.00	24,258,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,347,900.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	962,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	284,500.00	42,349,566.33
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,553,500.00
2105	Нормативт зардал	24,384,844.00	54,633,954.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,948,574.00	45,327,527.00
210502	Хоол, хүнс	6,236,270.00	6,797,427.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	2,509,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,112,000.00	1,928,000.00
210604	Урсгал засвар	1,112,000.00	1,928,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,456,000.00	983,000.00
210702	Дотоод албан томилолт	1,456,000.00	983,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,360,700.00	82,394,096.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,960,700.00	81,944,096.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,345,298.82	73,590,240.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,882.00	583,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,390,416.82	73,007,040.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	1,393,659.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,393,659.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,393,659.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,477,179.18	39,402,290.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,477,179.18	39,402,290.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	416,651,370.00	564,393,245.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,651,370.00	564,393,245.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,270,000.00	426,874,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,932,760.00	100,233,668.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,090,400.00	20,084,927.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,358,210.00	17,200,250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	411,375,370.00	558,663,245.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,375,370.00	558,663,245.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,194,401.00	557,269,586.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин	187,971,184.00	182,865,310.00
210102	Нэмэгдэл	66,980,600.00	96,453,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,082,000.00
210104	Урамшуулал	18,828,200.00	27,901,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
210201	Тэтгэврийн даатгал	25,951,805.00	28,914,615.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,740,900.00	3,128,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,192,700.00	2,502,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	548,200.00	625,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,481,800.00	6,256,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	20,034,750.00	19,656,927.00
210302	Түлш, халаалт	2,589,550.00	2,156,927.00
210303	Цэвэр, бохир ус	17,045,200.00	17,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210402	Тээвэр, шатахуун	26,282,640.00	33,191,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,900.00	1,199,500.00
210404	Ном, хэвлэл	20,719,940.00	26,285,130.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,471,800.00	1,306,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	300,000.00
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	3,150,000.00
210502	Хоол, хүнс	950,000.00	950,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,998,690.00	36,677,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,180,000.00	3,648,000.00
210604	Урсгал засвар	68,000.00	1,720,000.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	1,112,000.00	1,928,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,456,000.00	983,000.00
		14,360,700.00	103,862,204.00
		13,960,700.00	103,412,204.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,186,232.00	5,521,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,186,232.00	5,521,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,180,969.00	1,393,659.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,759,960.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,759,960.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	55,650.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,650.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,365,359.00	1,393,659.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,365,359.00	1,393,659.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,276,000.00	5,730,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,276,000.00	5,730,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,276,000.00	5,730,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,276,000.00	5,730,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,276,000.00	5,730,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,276,000.00	-5,730,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,036,798,998.81	00.00	1,298,486,113.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	53,634,333.00	00.00	53,634,333.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,090,433,331.81	00.00	1,352,120,446.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	53,634,333.00	00.00	00.00	-53,634,333.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	39,402,290.21	00.00	39,402,290.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,097,841.00	15,954,940.93	1,129,835,622.02	00.00	1,337,888,403.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	465,857,000.00	462,805,860.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,857,000.00	462,805,860.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,857,000.00	462,805,860.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,505,600.00	312,302,310.00
210101	Үндсэн цалин	183,068,600.00	182,865,310.00
210102	Нэмэгдэл	96,453,200.00	96,453,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,082,000.00	5,082,000.00
210104	Урамшуулал	27,901,800.00	27,901,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,228,700.00	41,426,715.00
210201	Тэтгэврийн даатгал	29,610,900.00	28,914,615.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,154,400.00	3,128,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,523,600.00	2,502,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	630,900.00	625,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,308,900.00	6,256,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,090,400.00	19,656,927.00
210301	Гэрэл, цахилгаан	3,590,400.00	2,156,927.00
210302	Түлш, халаалт	17,100,000.00	17,100,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,402,100.00	33,191,430.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,199,500.00
210402	Тээвэр, шатахуун	26,286,100.00	26,285,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,516,000.00	1,306,800.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,150,000.00	3,150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	950,000.00
2105	Нормативт зардал	36,978,300.00	36,677,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,718,300.00	28,418,300.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	5,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	2,509,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,600,000.00	5,528,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,600,000.00	3,600,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,928,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,007,200.00	983,000.00
210702	Дотоод албан томилолт	1,007,200.00	983,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,519,800.00	7,518,478.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,069,800.00	7,068,478.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5524900.00	5521700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,524,900.00	5,521,700.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	465,857,000.00	462,805,860.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	426,874,400.00	425,520,683.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,874,400.00	425,520,683.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,590,400.00	20084927.00
132001	Орон нутгийн төсвөөс	21,590,400.00	20084927.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,392,200.00	17,200,250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,392,200.00	17,200,250.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	6,086.00	6,086.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	434.00	434.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	5,652.00	5,652.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00
650010	Гэрээт ажилтан	03.00	03.00

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12932760.00	100,193,726.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12932760.00	100,193,726.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12932760.00	100,193,726.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12932760.00	100,193,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12932760.00	100,193,726.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		39,942.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2932760.00	100223668.00

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,932,760.00	64,612,668.00
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Энхтуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч О.Гандиймаа нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Д.Жавхлан нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нь хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш шударга үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад үйлчлүүлэгчдэдээ хамгийн ээлтэй тусламж үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагаар үнэлэгдэж иргэдэд хүргэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 100 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 439,848.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,597.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4948.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 7,965.9 мянган төгрөг буюу 4,023.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудын тэтгэмжийн 100,223.7 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 110,239.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайлан орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1397544.2 мянган төгрөг болж өмнөх оноос 96691.7 мянган төгрөгөөр буюу 7,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,476.9	138,884.3	114,407.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	110,239.0	110,239.0

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	24,476.9	28,645.3	4,168.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,276,375.5	1,258,659.9	(17,715.6)
Үндсэн хөрөнгө	1,491,982.3	1,547,273.7	55,291.4
Хуримтлагдсан элэгдэл	(215,606.8)	(288,613.8)	(73,007.0)
Нийт хөрөнгө	1,300,852.4	1,397,544.2	96,691.7
Өр төлбөр	2,366.3	59,655.8	57,289.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,298,486.1	1,337,888.4	39,402.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,300,852.4	1,397,544.2	96,691.7

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангийн

Бараа материалын дансны үлдэгдэл 28,645.3 мянган төгрөг болж 4168.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, ороох боох материалын дансны үлдэгдэл 3,741.6 мянган төгрөг болж 2,183.5 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл 6846.9 мянган төгрөг болж 4,103.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,547,273.7 мянган төгрөг болж 55,291.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5730.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авч, 13,321.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ЭМГ-аас дээд байгууллагаас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн, хандив болон бусад эх үүсвэрээс 36,240.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэгдсэн нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,337,888.4 мянган төгрөг болж 39,402.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд анх 465,857.0 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна. Тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 465,857.0 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 426,874.4 мянга, орон нутгийн төсвөөс 21,590.4 мянга, ЭМДС-гаас 17,392.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 426,874.4 мянга, орон нутгийн төсвөөс 20,084.9 мянга, ЭМД-аас 17,200.2 мянга, нийт 464,159.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 464,159.5 мянган төгрөгийг зарцуулж 1,353.7 мянган төгрөг буюу 0,3 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 1,505.5 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 0.2 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 464,159.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 1,433.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 100,223.7 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 64,612.7 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Корона вируст халдвартай тархсантай холбоотой тусгаарлах байрыг сургууль, спорт зал, соёлын төв, ЗДТГ-ын хуучин байранд бэлтгэсэн. Эмнэлэг, ЗДТГ-ын хуучин байранд улаан бүс болгож 25 ортойгоор дэлгэж 2021.08.31 –ны өдөр коронавирусын анхны тохиолдол бүртгэгдэж тусгаарлах эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, эмч сувилагч үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэй 7-14 хоногийн хугацаатай ажиллаж тусламж үйлчилгээгээ үзүүлсэн. Нийт 154 хүн батлагдаж эмчлэгдсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3-н бүлгийн 4 заалт бүхий зорилтыг дэвшүүлсэн. Хэрэгжилт-95%-тай гэж тайлагнагдсан.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 708083.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 221,279.5 мянган төгрөгөөр буюу 45,4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативт зардал 30249.1 мянган , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 68,033.4 мянган, хангамжийн материалын зардал 48,012.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын сар, улирлаар мэдээлэх 133,811.8 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрхи тогтоолд хамаарахгүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр шатах тослох материал худалдан авах гэрээг НИК ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Зөрчилгүй санал дүгнэлт авсан. Аудитаар 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Хэрэгжилтийг 2021.06.19-ний өдрийн 55 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 110,239.0 мянган төгрөгийн авлага, 59,655.7 мянган төгрөгийн өглөг үүссэнээс, цалинтай холбоотой 29,972.8 мянга, түлш шатахууны 1,371.0 мянга, эмийн 7,986.7 мянган төгрөгийн өглөг байгаа ба өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан тул цаашид түүний барагдуулалтыг шалгахад анхаарах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй ба шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг өгөв.

4.1 Зөвлөмж

4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

шалтгаан тайлбарын сар, улирлаар мэдээлэх 133811.8 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3.2, 6.1.6 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____